



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 01 сарын 21 өдөр

Дугаар А/23

Мандалговь

Тусламж үзүүлэх тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 “г”, Сангийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 318 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6 дахь заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2019 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 2 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Соёл урлагийн салбарт үнэтэй хувь нэмрээ оруулсан Дэлгэрхангай сумын уугуул Монгол улсын Хөдөлмөрийн баатар, Ардын жүжигчин дуурийн дуучин Гонгорын Хайдав таалал төгссөн явдалд гүн эмгэнэл илэрхийлж, буцалтгүй тусламж үзүүлсүгэй.

Хоёр. Тусламжид шаардагдах 500000 (таван зуун мянган) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Эрдэнэсүрэн), нягтлан бодогч (Д.Нандинцэцэг) нарт зөвшөөрсүгэй.



ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ

488010048